БАТЛАВ
ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
Б.ЗОРИГТБАЯР

ЗӨВШӨӨРСӨН
ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА
ЗАХИАЛАГЧИЙН АЛБАНЫ ДАРГА
БӨГӨӨД АЙМГИЙН ЕРӨНХИЙ
АРХИТЕКТОРЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОГ ГҮЙЦЭТГЭГЧ
Ц.ХИШИГЖАРГАЛ

ОРХОН АЙМГИЙН БАЯН-ӨНДӨР СУМ ИХ ЗАЛУУ БАГ
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 15 ДУГААР СУРГУУЛИЙН ЦАЙНЫ ГАЗРЫН ӨРГӨТГӨЛИЙН БАРИЛГЫН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ДААЛГАВАР

Дугаар .....

2025 оны 02 сарын 04 өдөр Эрдэнэт хот

Зураг төсөл боловсруулах үндэслэл	Орхон аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэрээр
Барилга байгууламжийн байршил	Орхон аймаг, Баян-Өндөр сум, Их залуу баг, 15 дугаар сургуулийн цайны газрын өргөтгөл
Зориулалт, хүчин чадал	15 дугаар сургуулийн цайны газрын өргөтгөлийн барилга
Архитектур төлөвлөлтийн объектын бүрэлдэхүүн шаардлага, хүчин чадал:	Уг барилга нь 15 дугаар сургуулийн цайны газраас хойш өргөтгөж барих 1 давхар барилга байна. 1-р давхарт: ➢ Цайны газрын үйлчилгээний заал ➢ Цайны газрын бэлтгэлийн өрөө
Технологийн шийдэл:	Олон нийтийн иргэний барилгын зураг төсөл боловсруулах, норм дүрэм болон одоогоор мөрдөгдөж буй холбогдох норм дүрмийг баримтлан орчин үеийн дэвшилтэт технологийг сонгох. /БНбД 31-03-03/;/БНбД 41-01-11/-г баримтлах, ерөнхий боловсролын сургууль НбД
Барилгын үндсэн бүтээц, хийцийн шийдэл	***Суурь***: Цутгамал төмөр бетон баганан суурьтай. Араг бүтээц: Төмөр бетон арагт бүтээц ***Гадна хана:*** Агааржуулсан блок, чулуун хөвөн хавтан, тоосгон өрөг, шавардлага будаг, БНбД материал ***Дотор хана:*** Тоосго ***Хучилт:*** Төмөр бетон цутгамал ***Дээвэр:*** Хавтгай дээвэр ***Цонх:*** 3 давхар шилтэй хуванцар рамтай цонх ***Хаалга:*** модон ***Цэвэр, бохир ус:*** Нэгдсэн тоолуур, галын насос, галын спринклер ***Халаалт:*** Энгийн босоо түгээлтийн систем ***Дотор цахилгаан:*** Хуванцар хоолойд сүвлэгдсэн ППВ, ПВ төрлийн евро стандарт хангасан зэс голтой кабель.
Зураг төслийн бүрдэл	- Загвар зураг - Ажлын зураг

	- Төсөв
Зураг төслийн байгууллага	- "Билиг хайрхан" ХХК
Зураг төсөл зохиох үе шат	- Нэг үе шаттай ажлын зураг
Захиалагч байгууллага	- Орхон аймгийн ерөнхий боловсролын 15 дугаар сургууль
Онцгой нөхцөл:	- Газар хөдлөлтийн 8 баллд тэсвэртэй
Галын аюулгүй байдал	- Барилга байгууламжийн галын аюулгүй байдал /БНбД 21-02-02/ - II зэрэг
Эдийн засгийн тооцоо, төсөв, ТЭЗҮ	- Төсвийг БНбД 81-95-12 дүрмийн дагуу эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн программаар тооцно. Нэгдсэн төсөв өртөгт: - Зураг төслийн үнэ - Захилагчийн хяналтын зардал - Зохиогчийн хяналтын зардалыг норм дүрмийн дагуу тус тус тооцож тусгана.

ХЯНАСАН:

АЗДТГ- ХБТХОХ

БАРИЛГА, ИНЖЕНЕРИЙН ШУГАМ СҮЛЖЭЭ

ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Р.ГАЛБААТАР

ОРХОН АЙМГИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН

15 ДУГААР СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ М.ГАЛБААТАР

БОЛОВСРУУЛСАН:

ОРХОН АЙМГИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН

15 ДУГААР СУРГУУЛИЙН СУРГАЛТЫН МЕНЕЖЕР Д.БАЯРБАТ

ОРХОН АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАР
ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН МАГАДЛАЛ ХИЙСЭН ТУХАЙ
ДҮГНЭЛТ

61000 Баян-Өндөр сум, Баянцагаан баг
УБД-2070001051, Утас/факс: 70350415
E-mail: orkhon.hyanalt@yahoo.com.http,www.nema.mn

_____2025.04.08_____ № _____02_____

"Билигхайрхан" ХХК-д

Нэг. Барилга байгууламжийн зураг төслийн мэдээлэл

1. Барилга байгууламжийн байршил: Орхон аймаг, Баян-Өндөр сум, Их залуу баг, багийн байрны зүүн талд, Боловсролын байгууллагын зориулалтаар эзэмшүүлсэн 15850 м.кв газарт.

2. Зураг төслийн компани: "Билигхайрхан " ХХК

3. Барилга байгууламжийн зориулалт: Улсын бүртгэлийн №0000069951 дугаар гэрчилгээтэй, Боловсролын байгууллагын зориулалттай. 2025 оны 02 дугаар сарын 04-ний өдөр Орхон аймгийн ерөнхий архитектурын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр баталсан архитектур төлөвлөлтийн №15 тоот даалгавартай, Батлагдсан эскиз зурагтай.

4. Барилга байгууламжийн давхар, талбай: 1 давхар, тэнхлэгээрээ 6.0 х 11.9 метр, Төмөр бетон цутгамал карзас.

5. Галд тэсвэршилтийн зэрэг: Төлөвлөсөн-II

6. Барилгын үүргийн галын аюулын анги: Ф 3.2

7. Зургийн иж бүрдэл: 7 хэсэг

Хоёр. Барилга байгууламжийн зураг
төслийн галын аюулгүй байдал

1. Гарцын /EXIT/ гэрэлтэгч тэмдэглэгээ гарцны хэсэгт стандартын дагуу байршуулах. /Цахилгааны тэжээлд холбогдох, цэнэгт зай хураагууртай болон фосфортдог/ Гал түймрийн үед нүүлгэн шилжүүлэх гэрэлтэгч тэмдэг, тэмдэглэгээ, ангилал. MNS GOST P 12.2 143-2012 стандартыг хангасан байх

Гурав. Ерөнхий дүгнэлт

Билиг хайрхан ХХК-ийн боловсруулсан 15 дугаар сургуулийн цайны газрын өргөтгөлийн барилгын зураг төсөлд Галын аюулгүй байдлын магадлал хийхэд илэрсэн 1 шаардлагыг зураг төслийн шатанд засварлан дахин холбогдох хэсэгт магадлал хийлгэх шаардлагатай буюу Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах магадлал хийх дүрмийн 5 дугаар зүйлийн 5.3 дах хэсэгт заасны дагуу дүгнэлт гаргав.

Дээрх шаардлагын дагуу ажлын зургийг засаж, нормын дагуу засвар хийгдсэн зургаар барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэн байх.

Барилгын зураг төсөлд өөрчлөлт оруулах тохиолдолд Онцгой байдлын байгууллагатай зөвшилцөж шийдвэрлэнэ.

Хянасан сар, өдөр	Тэмдэг дарсан хуудасны дугаарууд	Нэмэлт тэмдэглэл
2025.04.08	ХД 03	Барилгын ажлыг зураг төслийн дүгнэлтийн дагуу гүйцэтгэх.

ДҮГНЭЛТ ГАРГАСАН
ГАЛ ТҮЙМРИЙН УЛСЫН ХЯНАЛТЫН БАЙЦААГЧ,
АХМАД Л.БАТ-ИРЭЭДҮЙ

ОРХОН АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР

УЛСЫН БАЙЦААГЧИЙН ДҮГНЭЛТ

Уурхайчдын гудамж, Уурхайчин баг,
Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61049
Утас/Факс: (976) 7035 0659
Цахим шуудан: orkhon_emg@yahoo.com

2025.03.27 № 10-25-02/143/24

ГЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 15 ДУГААР СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ М.ГАЛБААТАРТ

Барилга байгууламжийн ажлын зураг төслийг хянасан тухай

Танай байгууллагын ирүүлсэн хүсэлтийн дагуу Орхон аймгийн Баян-Өндөр сумын Их залуу багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Ерөнхий боловсролын 15 дугаар сургуулийн цайны газрын өргөтгөлийн барилгын ажлын зургийг 2025 оны 03 дугаар сарын 26-ны өдөр хүлээн авч "Эрүүл ахуйн тухай" хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/441 дугаар тушаалаар батлагдсан "Барилга байгууламжийн зураг төсөл зохиох, барилга барих, ашиглалтад оруулахад эрүүл ахуйн хяналт хийхэд улсын байцаагчийн мөрдөх заавар"-ыг үндэслэн Эрүүл мэндийн яамны Салбарын хяналтын газрын даргын баталсан 10-00/01 дугаартай удирдамжийн дагуу барилгын норм, дүрэм, стандартуудад заасан нөхцөл, шаардлагыг хангаж буй эсэхэд эрүүл ахуйн төлөвлөгөөт урьдчилан сэргийлэх хяналт хийлээ.

Нэг. Барилга байгууламжийн нэр зориулалт:

Ерөнхий боловсролын 15 дугаар сургуулийн барилгын цайны газрын өргөтгөлийн барилга

Хоёр. Газар олголт:

Орхон аймгийн Засаг даргын 2017 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн А/249 тоот шийдвэрийг үндэслэн Баян-Өндөр сумын 19-р багийн нутаг дэвсгэрт байрлах багийн байрны зүүн талд, 6105301799 дугаар бүхий нэгж талбарт 15850 м2 газрыг боловсролын байгууллагын зориулалтаар 15 жилийн хугацаатай эзэмшүүлсэн. Гэрчилгээний дугаар: 00000069951.

Гурав: Архитектур төлөвлөлтийн даалгавар:

Орхон аймгийн Засаг дарга Б.Зоригтбаяр, Хот байгуулалт, барилга захиалагчийн албаны дарга бөгөөд аймгийн ерөнхий архитектурын үүргийг түр

орлон гүйцэтгэгч Ц.Хишигжаргал нар 14 заалттай даалгаврыг 2025 оны 02 дугаар сарын 02-ны өдөр хамтран баталсан байна.

Дөрөв: Зураг төсөл

Зураг төслийг "Билэгхайрхан" ХХК гүйцэтгэсэн. Зургийн шифр: БХ-01/2025. Нүүр хуудсанд захиалагч 15 дугаар сургуулийн захирал М.Галбаатар, "Билэгхайрхан" ХХК-ийн захирал Ц.Мөнхбат нар боловсруулж, гарын үсэг зурж зөвшөөрсөн байна.

Уг барилга нь одоо байгаа барилгын цайны газартай шууд холбогдож баригдах бөгөөд тэнхлэгээрээ 11.9 х 6.0 м, 71,4 м.кв талбайтай, 3,6 метрийн өндөртэй 1 давхар өргөтгөлийн барилга байна.

Хоол үйлдвэрлэлийн хэсэг нь гаднаас орох 2 хаалгатай, хаалгаар түүхий эд бүтээгдэхүүнээ оруулан агуулах болон бэлтгэх хэсэгт 1 чигийн урсгалаар оруулах бүрэн боломжтойгоос гадна ажилчдын хувцас солих өрөө, усанд орох, ариун цэврийн өрөөг төлөвлөсөн байна. Бэлтгэх хэсгээс халуун боловсруулах хэсэг рүү мөн адил 1 чигийн урсгалаар зөөгдөж, бэлэн болсон бүтээгдэхүүнээр хоолны зааланд үйлчилж, бохирдсон аяга тавгийг бохир хэсэг хүлээн авах хэсгээр хүлээн авахад эрүүл ахуйн дэглэм зөрчигдөхгүй байна.

Хооллох танхимын орох хэсэгт угаалтуурыг сурагчдын насны онцлогийг харгалзан 1-5 дугаар ангийн сурагчдад 0.5 м, 6-12 дугаар ангийн сурагчдад 0.7-0.8 м-ийн өндөрт байрлуулж, хана болон угаалтуурын хоорондын зай 1.9 м, 2 угаалтуурын хоорондын зай 2.2 м-ээс багагүй байхаар зураг төсөлд тусгах шаардлагатай.

Ус хангамж: Барилгын цэвэр усны эх үүсвэр нь төвлөрсөн систем бөгөөд ундны ус, хэрэгцээний халуун усны шугамыг сургуулийн барилга дотуур явж байгаа шугамаас авахаар зурагт тусгасан байна.

Бохир ус татан зайлуулалт: Бохир усны шугамыг 1 дүгээр давхрын шаланд өөрийн урсгалаар явуулж босоо шугамд холбож гадаа байгаа сургуулийн харъяаны бохир усны худагт холбохоор төлөвлөсөн байна.

Тав: Эрүүл ахуйн тухай хуулийн 5.3 дахь заалтыг үндэслэн **Дүгнэх нь:**

Ерөнхий боловсролын 15 дугаар сургуулийн цайны газрын өргөтгөлийн барилга нь сургалт хүмүүжлийн орчны эрүүл ахуйн шаардлага MNS 6799:2019, Ерөнхий боловсролын сургуулийн барилгын төлөвлөлт /БНбД 32-25-22/ стандарт, норм, дүрмийн шаардлага хангаж байна.

Энэхүү эрүүл ахуйн дүгнэлт нь Эрүүл мэндийн газрын Хяналт шалгалтын хэлтсийн ахлах байцаагчийн гарын үсэг зурж баталгаажсан нүүр хуудас болон

улсын байцаагчийн тэмдэг дарж баталгаажуулсан хуудас бүхий барилгын ажлын зураг төслийн хамт хүчинтэй.

Барилгын хянасан зураг төсөлд бичсэн тайлбар бичгээс өөр техник, технологийн шийдлийг хийх бол зураг төслийг дахин хянуулж баталгаажуулах шаардлагатай.

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх "Шалгуулсан байгууллага, аж ахуйн нэгжийн эрх баригч, албан тушаалтан хяналт шалгалтын явцад хууль тогтоомж зөрчигдсөн, гаргасан шийдвэр үндэслэлгүй гэж үзвэл гомдлоо хяналт шалгалт хийсэн байгууллагын эрх баригчид гаргана" заалтын дагуу гомдол гаргах эрхтэй болно.

ДҮГНЭЛТ ГАРГАСАН:

ЭРҮҮЛ АХУЙ, ХАЛДВАР ХАМГААЛЛЫН

ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ Б.СОЛОНГО

ХҮЛЭЭН АВСАН:

ЗАХИРАЛ М.ГАЛБААТАР

Дүгнэлт 2025